

ШҮҮМЖЛЭЛТ СЭТГЭЛГЭЭНИЙ ЧАДВАРЫН ЗАРИМ АСУУДАЛ

SOME PROBLEMS OF CRITICAL THINKING ABILITY

Л.Одзаяа

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, хошууч*

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд шүүмжлэлт сэтгэлгээний ойлголт, ач холбогдол, энэхүү ойлголтын талаарх эндүүрэл болон шүүмжлэлт уншлагын талаар өгүүлэх болно. Ер нь энэхүү ойлголт нь өнөө үед маш эрэлттэй чадваруудын нэг бөгөөд энэхүү сэтгэлгээний төрлийг хувь хүн танин мэдсэнээр шаардлагатай тохиолдолд өөрийгөө ч шүүн тунгааж чаддаг шинжлэх ухаанч хандлагатай хүн болж төлөвших ач холбогдолтой. Нөгөө талаас өөрийгөө өмөөрдөг, өрөвддөг, бусдын буруутгадаг, хов зөөдөг, болзол тавьдаг хүнийг төлөвшөөгүй хүн гэж дүгнэж болно.

Abstract: This article will focus on the concept and importance of critical thinking, the fallacy of this concept, and critical reading. In general, this understanding is one of the very sought-after abilities today, and with the individual's knowledge of this type of thinking, it is useful to develop into a person with a scientific attitude who can judge himself even if necessary. On the other hand, an immature person can be judged as someone who defends himself, sympathizes, blames others, harasses, and sets conditions.

Түлхүүр үгс: Шүүмжлэлт сэтгэлгээ, асуулт, анализ, тайлбарлах, үнэлэх, дүгнэлт гаргах, үндэслэгээ.

Keywords: Critical thinking, question, analyse, entrepret, evaluate, make a judgement, argument.

XXI зууны дэлхийн иргэнд байх ёстой ур чадварууд гэж байдаг. Тэдгээрийн нэг бол шүүмжлэлт сэтгэлгээтэй байх чадвар юм. Шүүмжлэлт сэтгэлгээтэй хүн гэж хэн бэ? Шаардлагатай тохиолдолд өөрийгөө ч шүүн тунгааж чаддаг шинжлэх ухаанч хандлагатай хүнийг хэлнэ. Нөгөө талаас өөрийгөө өмөөрдөг, өрөвддөг, бусдын буруутгадаг, хов зөөдөг, болзол тавьдаг хүнийг төлөвшөөгүй хүн гэж дүгнэж болно. Бидний өдөр тутмын амьдралд үнэн, худал нь үл мэдэгдэх асар их мэдээллийг нийтийн сүлжээ, сонин сэтгүүл, харилцаж буй харилцаа болон бусад эх сурвалжаас олж авч байдаг. Үүнд дүн шинжилгээ хийж, үнэн зөв мэдээлэл авахын тулд хүнд байх ёстой чухал чадварын нэг бол “шүүмжлэлт сэтгэлгээ” юм.

2400 гаруй жилийн өмнө Сократ шүүмжлэлт сэтгэлгээний онолын үндсийг дэвшүүлсэн байдаг. Тэр үед дэлхий ертөнц түүний санаа бодлыг хүлээн аваагүй бөгөөд нийгэмд үүнийг өргөн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай байгааг ч ойлгодоггүй байв. Өнөөдөр ч мөн адил шүүмжлэлт сэтгэлгээ нь “үнэлэгддэг” боловч хөгжөөгүй чадваруудын нэг нэг байсаар байна. Оксфордын толь бичигт “Шүүмж гэдэг нь аливаа асуудалд бодитой дүн шинжилгээ хийх, үнэлэх” гэж тодорхойлсон байдаг. Энэ нь харьцангуй энгийн мэт сонсогдож байгаа ч бид ихэвчлэн дүн шинжилгээ, үнэлгээний хэсэггүйгээр дүгнэлт гаргадаг.

Шүүмжлэлт сэтгэлгээ гэдэг нь мэдээллийг эмхэлж цэгцлэх, шалгах, үнэлэх, асуудлыг магадлалт олон талаас нь дүн шинжилгээ хийж¹⁷⁰, эцсийн үнэн зөв шийдэлд хүрэх чадварыг хэлнэ. Товчхондоо бол бодит нотолгоонд тулгуурлан асуудлыг шинжлэх, дүгнэлт гаргах явдал юм.

Шүүмжлэлт сэтгэлгээ гэдэг нь хүн төрөлхтөнд тодорхой сэдвийн талаарх одоо байгаа мэдээллийг задлан шинжлэх, үнэлэх чадварын илэрхийлэл бөгөөд өгөгдсөн мэдээллийн үнэн зөвийг тодруулж, энэ талаар үндэслэлтэй шийдэлд хүрэх чадварыг

¹⁷⁰ Дүн шинжилгээ хийхийн тулд баримт нотолгоо, учир шалтгаанууд, мөн орчин нөхцөлийг тодорхойлох шаардлагатай болдог.

илэрхийлдэг. Шүүмжлэлт сэтгэлгээг ашиглан ойлгосон зүйлийнхээ бодит байдлыг илрүүлж болно. Үүнийг тайлбарлахад ашигласан үндэслэлийг шинжлэн дүгнэвэл, Декартын санал болгосноор үнэнийг өгөх эсвэл догма ба туйлын аксиомуудад эргэлзэх явдал юм. Бодит байдлын талаар үндэслэлтэй ойлголттой болтлоо бусдын хэлсэн зүйлийг “сохроор” хүлээж авахгүй байхыг эрмэлзэх хэрэгтэй. Энэ төрлийн сэтгэлгээ нь эргэлзээтэй холбоотой байдаг ба хүн төрөлхтний хөгжлийн явцад бий болж, ялангуяа есвөр насандаа өөрийгөө таних чадварыг бий болгоход тусалдаг. Энэ нь дэлхий ертөнцийг эсэргүүцэх тухай биш, харин өгөгдлийг нягтлах, баталгаажуулах, ялгаатай байдалд үндэслэн өөрсдийнхөө үзэл бодлыг нарийвчлан боловсруулах боломж юм. Шүүмжлэлт сэтгэлгээ нь бүтээлч байдал, логик эсвэл зөн совин гэх мэт ойлголтуудтай нягт холбоотой бөгөөд шинэ стратеги, аливаа зүйлийг өөр талаас харах, ойлгох арга хэлбэрийг боловсруулах боломжийг бидэнд олгодог.¹⁷¹

Шүүмжлэлт сэтгэлгээ нь бусдын үзэл бодолд авталгүй, олон сонголтод тулгуурлаж, үнэн зөв дүгнэлт өгөхөд тусалдаг. Аль болох үндэслэлтэйгээр үнэнийг эрэлхийлж, хэлсэн хийсэн зүйл нь үнэн болохыг баримт, нотолгоогоор батлах чадвар юм. Жишээлбэл, таны сагсан бөмбөгийн дэмждэг тамирчин өөр багт элсжээ. Тэгвэл ямар шалтгааны улмаас, түүнд ямар хүчин зүйл нөлөөлсөн эсэх зэрэгт задлан шинжилж, дүгнэлт гаргах явдал юм. Ингэхдээ хувилбарт фактуудыг дутуу тооцоолсон хийдлээс болж таамаглалаас эсрэг шийдэлд хүрэхийг үгүйсгэхгүй. Гэвч шүүмжлэлт сэтгэлгээг амьдралдаа хэрэгжүүлснээр ихэнхдээ бид зөв шийдэлд хүрдэг.

Шүүмжлэлт сэтгэлгээ гэдэг нь тодорхой бөгөөд тууштай шалгуураар бидний үүсгэсэн эсвэл хүлээн авсан мэдээллийг зөв зохион байгуулах, шалгах, үнэлэх чадвар юм. Энэ нь юунд итгэх эсэхээ өөрсдөө шийдэх боломжийг олгодог бөгөөд тусгал эргэлзээг харуулах хандлага юм. Тиймээс өгөгдөл, баримт, илэрхийллийг тайлбарлах; хувийн дүгнэлт хийх; санаа, зорилго, үзэл баримтлал, аргументэд дүн шинжилгээ хийх чадвартай байхыг илэрхийлдэг. Шүүмжлэлт сэтгэлгээ нь оновчтой байдал, бие даасан сэтгэлгээний үндэс суурь юм. Энэхүү амин чухал ур чадварыг хөгжүүлэх нь тухайн хүнд юмсыг өөр талаас харах, үндэслэлтэй дүгнэлт хийх боломжийг олгодог ба чадварыг нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл хувийн мэдрэмж, хэн нэгний үзэл бодлын нөлөөгүйгээр бодитой сэтгэж, дүгнэлт хийх чадвар юм. Шүүмжлэлтэй сэтгэгч бол ямар нэгэн үйлдэл ба хариу үйлдлийн хооронд логик холбоо тогтоож, асуудлыг олж засварлаж, системтэйгээр шийдвэрлэж, аргументэд шүүлт хийх, нийтлэг алдаануудыг олж илрүүлэх чадвар юм¹⁷².

Шүүмжлэлт сэтгэлгээний талаарх эндүүрэл

Шүүмжлэлт сэтгэлгээ нь сөрөг байх, алдаа дутагдалд анхаарлаа хандуулах гэсэн үг биш юм. Харин аливаа асуудал эсвэл мэдээллийг задлан шинжилж, тайлбар боловсруулан ашиглаж үндэслэлтэй шийдвэр болон дүгнэлт гаргах гэсэн үг юм. Олон хүмүүс шүүмжлэлт сэтгэлгээг мэдлэгийн цуглуулга гэж андуурдаг. Харин түүнийг эзэмшсэн хүн мэдлэгээ ашиглах хандлагатай байдаг ба шинэ мэдээллийг хайж олохыг зорьдог. Өөр нэг нийтлэг буруу ойлголт бол шүүмжлэлт сэтгэлгээ гэдэг нь бусад хүмүүсийн хэлж, хийж байгаа зүйлд хэт эргэлзэх, шүүмжлэлтэй хандах тухай гэж ойлгодог. Өөрөөр хэлбэл шүүмжлэлтэй сэтгэлгээ гэдэг нь бүх зүйлд байнга сөрөг хандах, шүүмжлэх тухай асуудал биш юм.

Хүснэгт №1. Сэтгэлгээний ангилал.

Шүүмжлэлт сэтгэлгээ	Шүүмжлэлт бус сэтгэлгээ
Үл итгэдэг	Цээжлэн тогтоодог

¹⁷¹ URL: <https://musa.news/-аас үзэв>.

¹⁷² Duro E. et. Al. (2013) Сэтгэл судлал дахь шүүмжлэлт сэтгэлгээг эрэлхийлэх нь: дээд боловсролын сургуулийн оюутны болон лекторуудын ойлголтыг судлах. Сэтгэл судлал ба заах. 275-281 дэх тал.

Таамаглалыг шалгаж нягталдаг	Бүлгийн сэтгэлгээ
Ухаан сорьсон оюун дүгнэлт	Бусдын үзэл санааг сохроор буюу ямар нэг анализ дүгнэлт хийхгүйгээр хүлээн зөвшөөрөх

Шүүмжлэлт сэтгэлгээний ач холбогдол

Шүүмжлэлт сэтгэлгээ нь бусдын үзэл бодолд авталгүй, олон сонголтуудад тулгуурлаж үнэн зөв дүгнэлт хийхэд тусалдаг. Аль болох үндэслэлтэйгээр үнэнийг эрэлхийлж, хэлсэн хийсэн зүйл нь үнэн болохыг баримт, нотолгоогоор батлах чадвар юм.

Шүүмжлэлт сэтгэлгээг амьдралдаа хэрэглэснээр ихэнхдээ бид зөв шийдэлд хүрнэ. Өөрөөр хэлбэл ямар нэгэн хувийн мэдрэмжид тулгуурлаж, хэн нэгний үзэл бодлын нөлөөгүйгээр бодитой сэтгэж, дүгнэлт хийх чадвар юм. Шүүмжлэлтэй сэтгэгч бол ямар нэгэн үйлдэл ба хариу үйлдлийн хооронд логик холбоо тогтоож, асуудлыг олж харах, системтэйгээр шийдвэрлэж, аргументэд шүүлт хийх, нийтлэг алдаануудыг олж илрүүлэх чадвар юм.

Шүүмжлэлтэйгээр унших гэж юу хэлэх вэ?

Уран зохиолын бүтээлийг унших нь нарийвчилсан дүн шинжилгээ хийх үндэс суурь болдог. Эрдэм шинжилгээний өгүүлэгүүдийг шүүмжлэлтэйгээр унших нь эх сурвалж болон тэдгээрийн найдвартай байдлыг үнэлэхэд тус болно. Өөр хэн нэгний маргаанаас алдаа олох нь тогтворгүй байдлын цэг байж болох юм. Мөн сошиал медиагаар шуурхай хэвлэн нийтлэх боломжтой өнөө үед биднээс хэлж буй зүйлээ сайтар тунгаан бодохыг шаарддаг тул таныг мэтгэлцэх ур чадвараа хөгжүүлэхэд тусална.

Хэрхэн шүүмжлэлтэй унших вэ?

Энэ нь танд төрсөн зөн совин биш, харин 6000 жилийн өмнө хүн төрөлхтөн санаагаа илэрхийлэхийн тулд бэлгэдлийг ашиглаж эхэлснээр соёлын хөгжил эхэлсэн. Унших үйл явц нь зааварчилгаагаар дамждаг бөгөөд өөр зорилгоор хөгжсөн тархины механизмуудыг ажиллуулдаг. Унших нь харилцан үйлчлэлийн шинж чанар, хүмүүжил, соёлд тулгуурладаг сурсан чадвар юм. Энэ бол суралцах, дадлага хийх замаар хөгждөг танин мэдэхүйн хэрэгсэл юм¹⁷³.

Та яагаад шүүмжлэлтэй унших хэрэгтэй байна вэ? Энэ нь яагаад хамаатай юм бэ? Уншиж байгаа бүхнээ бүгдийг задлан шинжилж, шүүмжлэхгүйгээр зүгээр л таашаал авч чадахгүй гэж үү? Хэрэв та ямар ч төрлийн уран зохиол, алдартнуудын тухай сэтгүүл, комик ном гэх мэтийг уншиж байгаа бол таашаал авахын тулд унших нь гарцаагүй. Гэхдээ хэрэв та гэрээ, уран зохиол, мэдээ уншиж байгаа бол үнэн зөв мэдээллийг хүсч байдаг. Хуурамч мэдээ, худал сурталчилгаа, залилан мэхлэлт, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр худал хуурмаг мэдээлэл түгээмэл байдаг. Уншсан зүйлдээ сохроор итгэж, хүлээж авч болохгүй. Үүний тулд та шүүмжлэлтэйгээр унших чадварт суралцах хэрэгтэй.

Шүүмжлэлттэй уншихын ач холбогдол

Та шүүмжлэлтэйгээр уншиж сурсанаар илүү сайн, илүү ухаалаг уншигч болж, уншиж буй зүйлээ илүү гүн гүнзгий ойлгох болно. Та текстээс илүү ихийг олж авч, уншсан зүйлээ эргэн санах, үр дүнтэй мэдээллийг олж авч чадна. Энэ нь таныг "мэдээ" эсвэл ямар нэгэн алдартай номонд бичигдсэн эсвэл алдартай зохиолч шинжээч бичсэн учраас хуудсан дээрх үгсэд итгэмтгий, буюу сохроор итгэж, хүлээж авахаас сэргийлнэ. Энэ нь муу маргаан, баталгаагүй нотолгоо, төөрөгдөл, худал сурталчилгаа, худал мэдээ, суртал ухуулга, залилан гэх мэтийг илрүүлэхэд хялбар болгоно. Энэ нь таны шүүмжлэлт сэтгэх чадварыг сайжруулж, илүү ухаалаг болгоно. Номыг шүүмжлэлтэй уншихаасаа өмнө хамгийн эхний алхам бол уншихад үнэ цэнэтэй мэдээлэлтэй эсэхийг мэдэх явдал юм¹⁷⁴.

¹⁷³ URL: <https://pressbooks.howardcc.edu/criticalreadingcriticalwriting/chapter/chapter-1-critical-reading/-aac> үзэв.

¹⁷⁴ URL: <https://lifelessons.co/critical-thinking/critical-reading/-aac> үзэв.

Их сургуульд шүүмжлэлтэй унших нь ахлах сургуулиас юугаараа ялгаатай вэ? Их сургуулийн сургалт нь академик байдгаараа ахлах сургуулиас өөр юм. Таны хүлээж буй ажлын тоо хэмжээ нэмэгдэхийн хэрээр ажлын чанар ч өөрчлөгддөг. Та хичээлийн материалыг ойлгож, шалгалт өгөхөөс илүүг хийх ёстой. Та шинэ санаануудыг эргэцүүлэн тунгааж, дүн шинжилгээ хийж, шүүмжилж, холбоо тогтоож, дүгнэлт хийж, эсвэл тэдний талаар бодох шинэ арга замыг олох замаар нухацтай оролцох болно. Боловсролын хувьд та илүү гүн ус руу шилжиж байна¹⁷⁵.

Шүүмжлэлтэйгээр унших чадвар

Үр дүнтэй уншихын тулд текстэд шүүмжлэлтэйгээр хандах шаардлагатай. Зөвхөн юу гэж бичсэнийг бус, яаж, яагаад ингэж бичсэнийг анхаарч унших нь үр дүнтэй уншихын гол зорилго юм. Үр дүнтэй судалгаа (эх сурвалжийг үнэлэх үед) болон үр дүнтэй бичвэрийг (хэрэв та өөрийн бичсэн зүйлээ хэрхэн бичсэн)-ийг уншиж ойлгохын тулд дараах арга техникийг эзэмших боломжтой. Үр дүнтэй уншигч байна гэдэг нь өөрөө дадлага хийж, шүүмжлэлтэйгээр унших чадвараа хөгжүүлж, өөрийнхөөрөө үнэлж дүгнэх чадвартай байна гэсэн үг.

Юуны төлөө уншиж байгаагаа тогтоох

Текстийг уншихаасаа өмнө дараах асуултуудыг асууж, хариулах байдлаар үр дүнтэй уншиж болно. Зөвхөн ерөнхий агуулгад зориулж унших уу? Тодорхой мэдээлэл эсвэл ерөнхий сэдэвчилсэн асуудалд уу? Таны бичвэрийг дэмжсэн эсвэл няцаасан аргууд байна уу?

Үр дүнтэйгээр уншихад хангалттай цаг зарцуулах

Шүүмжлэн унших нь богино хугацаанд болох тийм ч хурдан үйл явц биш. Бүх зүйлийг хэтэрхий хурдан буюу хангалттай цаг гаргалгүй унших нь үр дүнтэй унших үйл явцад сөргөөр нөлөөлнө. Иймээс шүүмжлэлтэйгээр уншихдаа хангалттай цаг зарцуулж дахин унших цаг гаргах хэрэгтэй. Та юуны төлөө уншиж байгаагаа мэдэж байвал мэдээллээс тоймлож болох ба мэдээллийг шалгах, унших цагаа илүү сайн ашиглаж, илүү нягт нямбай байх ёстой гэдгээ ойлгож чадна. Таны мэдэж байгаа мэдээлэл нарийвчлан уншиж эхлэхээс өмнө текстийг урьдчилан харж эсвэл судалж, сэжүүр хайх, хамрах хүрээ, хүндрэл, үндсэн сэдэвтэй хэрхэн холбогдож байгааг олох нь чухал юм.

Хүснэгт №2. Энгийн уншлага ба шүүмжлэлтэй уншлагын харьцуулалт.

Унших	Шүүмжлэлтэйгээр унших
Текстийн үндсэн ойлголтын тухай	Тексттэй хэрхэн ажиллаж дүгнэлт гаргах
Ойлгох	Дүн шинжилгээ хийх, тайлбарлах, үнэлгээ өгөх
Текст гэж юу вэ?	Текст нь ямар утгатай, юуг хэрхэн илэрхийлдэг вэ?
Текст юуг илэрхийлж байна вэ? Текстээс ямар мэдээлэл авч болох вэ?	Ямар төрлийн үндэслэл, нотлох баримтыг ашигласан бэ? Үндсэн таамаглалууд юу вэ? Текстэд юуг өгүүлж байна вэ?
Текстийн агуулгыг хүлээн зөвшөөрөх	Текстийн эсрэг буюу байр суурьтай байх буюу өөр өнцгөөр харах /текстэд таамаглал дэвшүүлж, текст дэх утгыг тайлбарлах/

Дахин унших нь үр дүнтэй буюу шүүмжлэлтэй уншихын чухал хэсэг гэдгийг санах

Нэг хүнтэй нэгээс олон удаа ярилцах нь ойр дотно болоход хүргэдэгтэй адил олон удаа унших нь текстийн утга учрыг илүү олгоход тусалдаг. Хэрэв та анх уншихдаа үндсэн мэдээлэл, зорилготой танилцсан бол дараагийн уншлага нь янз бүрийн зүйлд төвлөрүүлдэг.

¹⁷⁵ URL: <https://pressbooks.howardcc.edu/criticalreadingcriticalwriting/chapter/chapter-1-critical-reading/>-аас үзэв.

Дахин уншихдаа аргументуудын хэсгүүдийг (жишээ нь, дипломын ажлын санаа, нотлох баримт, таамаглал, эсрэг аргументууд) болон эдгээр хэсгүүдийг дэмжихийн тулд хэрхэн ажилласныг ойлгох зорилгоор зохиолчийн дипломын ажлыг уншиж болно. Ойлгож уншихын тулд тэмдэглэгээ ашиглаж болно. Үзэг эсвэл харандаагаар гол өгүүлбэр, хэсгүүд тодруулж уншина. Эдгээр нь танд төөрөгдөлтэй санагдаж, ойлгохгүй байгаа үг, нэр томъёогоо тэмдэглэхэд хэрэгтэй юм. Тиймээс танд дараа нь олоход хялбар болно. Текст, лекц эсвэл хэлэлцүүлэгт хаана, хэрхэн холбогдож байгааг, мөн ерөнхийд нь тэмдэглэж болно. Эсвэл багшаасаа хичээл эсвэл ажлын цагаар асуухыг хүсч буй асуултуудыг тэмдэглэн асууж болно. Өөрийн асуух асуулт болон санал нийлэх эсвэл санал нийлэхгүй байгаа зүйлээ тэмдэглэж, гол санаа, санаанууд хоорондоо таарч тохирох буй эсэхийг тэмдэглэнэ. Өөрөөр хэлбэл, тексттэй харилцан яриа өрнүүлж, тэмдэглэж, өөрийн болгохоор ажиллана. Шүүмжлэлтэй унших нь хүүрнэн уншихаас илүү идэвхтэй унших арга юм. Шүүмжлэлтэй унших нь дүн шинжилгээ хийх, тайлбарлах, заримдаа үнэлэх үйл явц болдог. Тухайлбал шинжлэх ухаан, гүн ухаан, уран зохиол гэх мэт хичээлүүдийг шүүмжлэлтэй унших шаардлагатай байж болно.

Дүгнэлт

Шүүмжлэлт сэтгэлгээ нь бусдын үзэл бодолд авталгүй, олон сонголтуудад тулгуурлаж үнэн зөв дүгнэлт хийх чадвар юм. Шүүмжлэлт сэтгэлгээг амьдралдаа хэрэглэснээр бид зөв шийдвэр гаргаж, дүгнэлт хийдэг. Хувийн мэдрэмжид тулгуурлалгүй, хэн нэгний үзэл бодлын нөлөөгүйгээр бодитой сэтгэж, дүгнэхэд суралцдаг. Шүүмжлэлт сэтгэлгээ бол сөрөг хандлага, юмыг үгүйсгэх няцаах гэсэн үг биш юм.

Шүүмжлэлтэйгээр сэтгэх чадвар нь тухайн зүйлийн гадаад үзэмжид бус харин дотоод мөн чанар, ямар утга учирт гол анхаарлаа хандуулдаг. Мөн энэ чадвар нь шүүмжлэлтэйгээр уншиж, бичих чадварыг давхар хөгжүүлдэг. Шүүмжлэлтэйгээр унших, бичих чадвар нь өнөө үед зайлшгүй эзэмших ёстой чадваруудын тэргүүн эгнээнд багтаж буй ур чадваруудын нэг юм. Шүүмжлэлт уншлага нь дүн шинжилгээ хийх, тайлбарлах, заримдаа үнэлэх үйл явц болдог. Бид уншиж байхдаа шүүмжлэлтэй хандвал асуулт асуух болон текст уншихдаа шүүмжлэлтэй сэтгэх чадвараа ашигладаг.

Ашигласан материал

1. <https://musa.news/-aac> үзэв.
2. Duro E. et. Ал. (2013) Сэтгэл судлал дахь шүүмжлэлт сэтгэлгээг эрэлхийлэх нь: дээд боловсролын сургуулийн оюутны болон лекторуудын ойлголтыг судлах. Сэтгэл судлал ба заах.
3. <https://pressbooks.howardcc.edu/criticalreadingcriticalwriting/chapter/chapter-1-critical-reading/-aac> үзэв.
4. <https://lifelessons.co/critical-thinking/critical-reading/-aac> үзэв.
5. <https://pressbooks.howardcc.edu/criticalreadingcriticalwriting/chapter/chapter-1-critical-reading/-aac> үзэв.